



SGP
The GEF
Small Grants
Programme



Эрүүлжүүлэг
Сектор



Зөгий маллах Гарын авлага

*Алт олборлоход монгол усыг хэрэглэнээс
гаргах төсөлд хамрагдагсдад зориулав*

"Дэлхий дээр зөгий уствал 4 жилийн дараа хүн төрөлхтөн мөхнө" хэмээн А.Эйнштейн нэгэнтээ хэлжээ. Зөгий бол дэлхий дээрхи амьд биетүүдээс эд эсийн хувирал мутацад ордоггүй цорын ганц амьтан болохоос гадна бал, лав, жилий, сүүнцэр, хор, тоосоромг зэрэг 12-13 төрлийн хоол хүнс, эмчилгээ, сувилгааны, түүнчлэн үйлдвэр, хөдөөд аж ахуй, сансрын техникт ач холбогдолтой бүтээгдэхүүн өгдөг маш ашигтай амьтан юм. Зөгийн бал олон жил чанараа алддаггүй, хөгцөрч муудадаггүй гайхалтай ариутгагч шинж чанартай. Баланд 18 хувийн ус, 80 хувийн чихэрлэгийн зүйлс байдгаас гадна цардуул, уураг, А,В,С витамин, янз бүрийн хорт бичил махбодыг устгагч зэрэг нийтдээ 100 гаруй төрлийн бодис агуулагддаг байна.



Зөгийн бүлийн бүтэц бүрэлдэхүүн

Зөгийн бүл: Зөгийн бүл гэдэг нь ганц эх зөгийтэй олон тооны ажлын зөгий нэг үүрэнд сүрэглэн амьдрах бүлэг зөгий юм. Мөн цөөн тооны эр зөгий хавраас намар хүртэл хамт байна.

Эх зөгий: Үүр бүрт ганцхан эх зөгий байх бөгөөд тэрбээр үүрэндээ байнга байж өндөглөх, үр удмаа үргэлжлүүлэх үүргийг гүйцэтгэнэ. Дунджаар 3-5 жил насалдаг, өндөглөх ашигтай хугацаа нь 2-3 жил, ид өндөглөлтийн үедээ өдөрт 1500-3000 хүртэл өндөг гаргах бөгөөд үүрэндээ ажлын хуваарийг алдагдуулахгүй байхад нөлөөлдөг бодис ялгаруулж байдаг байна. Биеийн урт дунджаар 20-25 мм.

Ажилчин зөгий: Ажилчин зөгий бол үүрний бүх ажлыг хийдэг эмэгчин зөгий юм. Ажилчин зөгий нь үүр барих, засах, өндөг, авгалдай тээжэх, эх зөгийг асрах, ургамлаас амтат шүүс цулуулан бал боловсруулах, үүрэн доторхи дулааны хэмийг тохируулах, бүлээ бусад дайсангагч амьдаас хамгаалах зэрэг олон үүрэгтэй. Зуны эрчимтэй ажлын үед ердөө 35-45 хоног, өвөлжилтөнд орсон тайван байдлынхаа үед 7-8 сар амьдарна. Биеийн урт дунджаар 12-14 мм.

Эр зөгий: Эр зөгий нь хавар, зуны улиралд зөгийн бүлд гарч ирдэг. Тэд ямарч ажил хийдэггүй, зөвхөн эх зөгийг үр толгоох үүрэгтэй, 2-3 сарын настай. Бадриун биетэй, урт нь 15-17мм. Эр зөгий их тэжээл хэрэглэдэг тул тоог нь хязгаарлаж байх шаардлагатай. Эр зөгий хавар өвөлжөөнөөс гарсны дараа бойжиж зуны туршид байх боловч намар анхны хяруу унах үеэр ажилчин зөгийнүүд түүнийг үүрнээсээ хөөж өгүүтгэдэг.

Зөгийн үржил, хөгжил

Хаврын арчилгаа дууссаны дараа зөгийн үржлийн ажил явагдана. Үүний өмнө шилмэл бүлүүдийг сонгож үржлийн ажлыг гарфикийн дагуу явуулахын тулд эцэг бүл, эх зөгий шинээр гаргах бүл, авгалдай бойжуулах бүл зэргийг бий болгоно. Эцэг бүл бэлтгэхдээ эх зөгий гаргахаас 14 хоногийн өмнө эр зөгий гаргах бүлээ сайн чанарын тэжээлээр тэжээж эр зөгийний ташаалавчтай сархиагыг өндөглүүлэхээр тавьж өгнө. Эх гаргах бүлийг нэмэлт тэжээл өгч 3 настай авгалдайг бойжуулгын бүлд тавьж тэжээлгэч эх гаргах торнивчийг бүрдүүлнэ. Эхийг нь тусгаарласан хүчтэй бүлийг бойжуулгын бүл болгож авна. Эх зөгий бие гүйцээний дараа салхигүй, нартай дулаан өдөр үүрнээсээ өвөрмөц авиа гарган нисэхэд эр зөгийнүүд дагалдан нисэж газраас 50 орчим метр өндөрт хээл авна. 6-10 орчим эр зөгийтэй нийлүүлэгт орж хээл авсны дараа 2-3 хоноод өндөглөж эхлэх бөгөөд эрчимтэй өндөглөж эхлэх үед нь өндөглөх сархиаг бүхий жаазыг цаг алдалгүй тавьж өгч байх шаардлагатай.



© 2006 Encyclopædia Britannica, Inc.

Зөгийн амьдралын үе шатууд	Эх зөгий	Ажилчин зөгий	Эр зөгий
Өндөг	3 хон	3 хон	3 хон
Авгалдай	5	6	7
Тэрэлдэй	2	3	4
Хүүхэлдэй	6	9	10
Бие гүйцэх	16	21	24
Амьдрах хугацаа	1-6 жил	32-45 хон	2-3 сар

Эх зөгий гаргах

Авгалдайг ташаалавчтай тавьж бойжуулах арга: Нэг өдрийн настай өндөг бүхий ташаалавчийг хурч хутгаар хэрчин авч өндөгтэй ташаалавчуудаа нэг нэгээр салган жижиг модон товхон дээр лав хайлуулан нааж бэхлэнэ. Эх зөгийг бойжуулахад зориулсан жаазанд хөндлөвч мод бэхлээд дээрх товхтой өндөг бүхий ташаалавчуудаа байрлуулна. Хөндлөвч бүрт 10-13 товхтой өндөг бүхий ташаалавчийг байрлуулна. Өндгөө дааруулахгүй тулд 20-250С хэм дулаантай байранд хийнэ. Бойжуулагч бүлд 30-40 эх зөгий болох өндгийг тавьж өгнө. Ингээд ажлын зөгий тэднийг тэжээж байгаа эсэхийг шалгаж тэжээгээгүй бол дахин тавьж өгнө. Эх зөгий нь 16 хоногт бие гүйцэж өсөх тул энэ өдрөө бие гүйцсэн эх зөгийнүүдээ өлгийвчтэй нь эх зөгий хадгалах торонд хийнэ.

Авгалдай зөөвөрлөх арга: Эх зөгий гаргах зөөвөрлөх байр нь шэрэлтүүлэг сайтай, 25 хэм дулаан, 80 хувийн чийгтэй байвал зохино. Ташаалавчны ёроолд байгаа 3 хоногийн настай сүүнцэртэй өндгийг тусгай этүүрээр болгоомжтой авч өлгийвчинд хийнэ. Өлгийвчийг чанартай лаваар урьдчилан бэлтгэх бөгөөд жижигхэн модон торхонд бэхлэнэ. Тэжээсэн авгалдайг 18-20 цагийн дараагаар сүүнцэрээс салгаж 0.5-1 хоногийн настай өндгийг суулгаж өгч тэжээнэ. Ийнхүү 1 өндөг 2 авгалдайд шаардагдах сүүнцэртэй болно. Авгалдайг 2 дахин зөөвөрлөснөөс хойш 5-6 хоногийн дараа битүүмжлэгдсэн өлгийвчөө тоолно. Бойжсон өлгийвчтэй эхээ болгоомжтой авч эх зөгий хадгалах торонд хийнэ. Эх зөгийг хавар зөгийн бүлд эр зөгийн үрвэлдэй бий болох үед гаргаж эхлэх нь зүйтэй.

Бүлэнцэр бүрдүүлэх

Зөгийн бүлээс шинэ бүлэнцэр бүрдүүлэх хэд хэдэн арга бий.

Нислэгээр хуваах арга: Хүчтэй бүл байрлуулсан байран дээр өөр гэр буюу үүр тавина. Энэ гэрэнд янз бүрийн настай өндөг, авгалдайдтай 3-4 ширхэг сархийгийг эх зөгийтэй нь хамт үлдээнэ. Дараа нь өмнө нь байсан бүлээ зайлуулж тавина. Эхгүй болсон бүлдээ эх зөгий тавьж өгнө.

Эх тавьж бүл таслах арга: Бүрдүүлж байгаа бүлэнцэртээ шууд хээлтэй эх зөгий тавьж өгөхөөс гадна эх зөгий гаргах өлгийвч тавьж өгнө. Эх бүлээс янз бүрийн настай өндөг авгалдайдтай 3-4 сархийг гаргах шимэн гэрт хийгээд эх бүлийнхээ дэргэд тавина. Нислэгийн зөгий эхний үед хуваагдаж орох явдал бий. Иймд эх бүлээс аажмаар холдуулж зайтай болгоно.



Сүргээр бүлэнцэр бүрдүүлэх арга:

Зуны улиралд зөгийн бүл сүрэлгэх хандлага их байдаг. Бүлийн дотор 2 буюу хэд хэдэн эх зөгий гарах тохиолдол бий. Ингэхэд эх зөгийнүүд бие биесэс дайжин гэрээсээ гарч хэсэг ажлын зөгийг дагуулан ниснэ. Ингэж олон тооны зөгий эхийгээ даган суурийн ойролцоох модны мөчир, хад, чулуу мэт өндөрлөг орчинд шавсааралдан байрлана. Үүнийг зөгий сүрэлгэх гэнэ. Ийм сүргийг иштэй торон уут маягийн хэрэгслээр хаман авч баруурт хийнэ. Дараа нь бариуртай зөгийн сүргээ жааз сархиагтай гэрт хийж тавина. Зураг

Зөгийг арчлах

Сайн арчилсан зөгий хүчтэй, тэжээл бага зарцуулдаг, өвчинд нэрвэгдэхгүй, түргэн өсдөг, бүтээгдэхүүн сайтай байдаг. Арчилгааг хийхдээ:

- Тайван хөдөлгөөнөөр нягт нямбай хандах;
- Зөгийд үзлэг хийхдээ ховхчуур, эрвэгэнүүр, алх гэх мэт багаж бүхий ажлын хайрцаг, сэмжтэй жааз, утуураа бэлтгэж малгай, ажлын хувцсаа өмссөн байх;
- Агаарын хэм сүүдэр газраа 120С-ээс доошгүй дулаанд, зуны улиралд өглөө эсвэл халуун өнгөрсний дараа үзлэг хийх;
- Зөгийг цочоож уурлуулахгүй, нислэгт саад болохгүйгээр гэрийн хажуу талаас үзлэг хийх;
- Үзлэгийг хийхдээ эхлээд тагийг авч ар талд нь тавиад дараа нь бүтээлэг даавууны өнцгийг яльгүй сөхөж утуураар зөөлөн утна. Дээд хэсгийн зөгий доош орсны дараа үзлэгээ эхлэх, захын жаазыг авч үзэсний дараа зөөврийн хайрцагтаа хийж дараагийн жаазыг гэрийн хана руу шахаж тавих, Өндөгтэй жаазыг голд, балтайг нь захад байрлуулах;
- Жаазыг зөгийнүүдээс суллахдаа гэрийн дотор жаазын хагасыг оруулж чихэвчин дээрээс нь барьж хүчтэй сэгсэрэх, зөгий үлдвэл эрвэгнүүрээр доош унагах;
- Зөгийн бүлийн хүчийг 2 сархиагны хоорондох зай буюу зөгийн тоогоор тодорхойлох, үзлэгийг дахин дахин бус цаг хугацаанд нь 1 удаа чанартай хийх нь зүйтэй.



Зөгийн бүлд дараах үндсэн үзлэгүүдийг хийнэ. Үүнд:

- Хаврын түргэн үзлэг
- Хаврын их үзлэг
- Давхраа давхцуурыг нэмж өргөтгөхийг өмнөх үзлэг
- Гол авцанд бэлтгэх, өргөтгөх үеийн үзлэг
- Гол авцын дараах үзлэг
- Намрын их үзлэг

Зөгийчний үндсэн ажлын хуанли

Хугацаа /сар/	Ажлын үе шатууд	Зөгийчний хийж ажил
I-III	Зөгийний өвөлжилтийн 2 дугаар үе	Зөгийн бүлийг 7-10 хоногт тогтмол шалгаж байх, гэрийн нисгэвчийн хэсгийг цэвэрлэх, өвөлжөөний агаарын чийг, дулааныг тогтмол үзэж тэмдэглэх, хулгана байгааг эсхийг мөн бүлийн тэжээлийн зөрчүүллэгийг шалгаж байх.
IV-VI	Зөгийний хаврын хөгжлийн үе, бүл өргөтгөх, гол авцанд бэлтгэх	Зөгийг өвөлжөөнөөс гаргаад тавих талбайг цэвэрлэж бэлтгэх, услуу, гэр доторхи гадас, тавиур бэлтгэх, зөгийг өвөлжөөнөөс гаргах /10-12С/ дулаан хэмтэй, салхигүй өдрийг сонгоно/, хаврын түргэн болон их үзлэг хийх, Зөгийн үүрийн хана, ёроолыг хусаж цэвэрлэж үхсэн зөгийнүүдийг зайлуулах; Тэжээл дутагдалтай бол нэмж өгөх, хаврын улиралд нэг бүлд 1:1 харьцаатай элсэн чихрийн уусмалыг 300-400 грамм, мөн уурагт тэжээл өгөх, эхгүй болсон бүл байвал эхтэй бүлд нийлүүлэх, бүл нэгтгэх, өргөтгөх, шаардлагатай бол эх зөгийг солих, гэр, Давхрааг дулаалах, засаж тавих, илүү жаазыг авч шахаж дулаалах.
VII	Гол авцын үе	Эх зөгий гаргах, бүлэнцэр бүрдүүлж эхлэх, бүлийг өргөтгөх, балт ургамлын цэцэглэлтийн байдлыг харгалзан отор нүүдэл хийх, Бал хураах.
VIII	Бал хураалт, өтөлжилтөнд бэлтгэх, бүл өргөтгөх	Бал хураалт хийж дуусгах, намрын их үзлэг хийж шаардлагатай бүлд нэмэлт тэжээл өгөх, зөгийн бүлийг тэжээж жаазыг шахан дулаалж өвөлжилтөнд бэлтгэх.
IX	Дээрхийн адил	Бүл бүрийн тэжээлийг шалгаж шаардлагатай бүлийг 6-8 кг чихрийн уусмалаар тэжээх, бүл бүрийг дулаалах, өвөлжихөд бэлтгэх.
X	Дээрхийн адил	Гадаах агаар 0°С хэм болсон үе буюу 10 дугаар сарын сүүлчээр зөгийн бүлийг өвөлжөөнд оруулах, багаж төхөөрөмжөө цэвэрлэж хадгалах.
XI-XII	Зөгийний өвөлжилтийн 1 дугаар үе	Зөгийг өвөлжөөнд байгаа хугацаанд сард 2-оос доошгүй удаа шалгаж байх.



Зөгийг өвөлжүүлэх

Зөгийн өвөлжөөг сайн дулаалж агааржуулсан, 1-30С хэмийн дулаантай, 70-80%-ийн чийгшилтэй, дуу чимээ нэвтрэхгүй, зам харгүйгаас хот тосгоноос хол зайтай, ус орохооргүй, нөмөр дулаан, нэрэн эвэр эрүүл хөрстэй газарт байлгах шаардлагатай. Зөгийн өвөлжөөнд 10-14 хоног тогтмол үзлэг хийж дулааны хэмийг тохируулж байна. Зөгийг өвөлжүүлэхэд өөрийнх нь цуглуулсан балаар тэжээх нь үр дүнтэй бөгөөд нэг бүлд 25кг-аас доошгүй бал, 4-5 кг тоосормогийн нөөц байх шаардлагатай.

Зөгийн тэжээл

Зөгий цэцэгт ургамлаас чихэрлэг шингэнийг цулуулж боловсруулан бал болгож тэжээлдээ хэрэглэнэ. Дундаж хэмжээний хүчтэй нэг бүл жилд дунджаар 75-100 кг бал, 20-25 кг тоосормог буюу цэцгийн боловсруулсан тоос хэрэглэнэ. Залуу ажлын зөгий сүүнцэр ялгаруулж өндгийг 3 хоног тэжээдэг бол эх зөгий тэжээлдээ сүүнцэрийг байнга хэрэглэснээр харьцангуй урт насалдаг. Харин зөгий авгалдай, хүүхэлдэй үедээ бал, тоосормогийн нухшаар хооллодог байна. Хавар намар тэжээл хомс үед элсэн чихрийг устай 2:1 харьцаатайгаар найруулан тэжээнэ. Нөөц тэжээл багатай бол намар нэг бүлд 8-10кг байхаар бодож элсэн чихрийн уусмалаа 45-50 хэмийн бүлэнтэйгээр тусгай идүүрт хийж тэжээнэ. Мөн эмчлэх шаардлагатай бол эмч мэргэжилтний зөвлөгөөгөөр тусгай жороор найруулсан эм тэжээлд нь нэмж өгнө. Мөн элсэн чихрийн нунтаг, цэцгийн балыг найруулж хэрэглэхээс гадна Орос улсын Апилекарь, Апивитаминка, Пчелодар зэрэг идэвхижүүлэх тэжээлүүд өгвөл үр дүн сайтай.

Балт ургамлын нөөц

Цэцэглэх үедээ амтат шүүс ялгаруулдаг ургамлыг балт ургамал гэнэ. Манай оронд 60 овгийн 197 төрөлд багтах 574 зүйлийн балт ургамал бий. Энэ нөхцөл байдалд тулгуурлан 2 сая зөгийн бүл үржүүлэх боломжтой гэсэн тооцоотой аж. Хэнтий, Хангай, Хөвсгөл, Хан-Хөхий, Хянган орчимд балт ургамал ихтэй. Түүнчлэн таримал балт ургамлын бэлчээр бий болгож ашиглавал аж ахуйн ашиг ихтэй байдаг.

Зөгийн отор нүүдэл

Балт ургамлын нөөц, зүйлийн бүрдэл, цэц эглэх хугацаа, тухай нутгийн онцлогийн харгалзан зөгийн отор нүүдлийг байнга хийх шаардлагатай. Зөгийг өвөлжөөнөөс гарганлуут салхины хүчтэй урсгал багатай нөмөр дулаан газар, бургас, яргуй, гичгэнэ, гүйлс, буйлс зэрэг хавар эрт цэцэглэдэг ургамлуудын үе шатны хугацааг харгалзан манай орны ойт хээрийн бүсийн ихэнх нутагт 6 дугаар сарын эхний 10 хоногос 8 дугаар сарын гуравдугаар 10 хоног хүртэл зөгийн отор нүүдлийг хийнэ. Зөгийн нислэг дууссаны дараа үдэш эсвэл өглөө эрт нүүлгэнэ. Зөгийгөө зөөхийн өмнө зөгийн гэрийн доторх болон гаднах бэхлэгээ сайн хийж ачихдаа нисгэвчийг хаана. Зөгийг 25-30 бүлээр суурилах бөгөөд суурийн хооронд 10-15 км орчим байхад тохиромжтой.

Зөгийн өвчин, хорлогчид

Зөгийд олон тооны өвчин хорлогчид бий. Тэдгээрээс зөгийг хамгаалж эрүүл байлгах нь авах бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх нөхцлийн нэг болдог. Зөгийн өвчнийг халдвартай, халдваргүй гэж ангилна. Түгээмэл тохиолддог өвчнүүд гэвэл нян, хоруу мөөгөөр өвчлөх, америкийн үжил, европын үжил, чулуун болон шохойны хүүршил, үрвэлдэйн хүүршил, спор, халдварт цацга, хачигтах, үргүйтэх зэрэг болно. Зөгийг өвчин, хортноос хамгаалахын тулд:

- Зөгийн бүлийн арчилгааг сайжруулж цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хийх;
- Өвчтэй бүлийг тусгаарлан жааз, давхраа, гэрийн ул, таг, зөөлөөч даавуу, дулаалгыг ариутгах;
- Өвөлжөө, загийн суурь орчмын талбайг байнга ариутгаж байх;
- Өвчнийг зөв таньж тохирсон эмчилгээг цаг алдалгүй хийх;
- Зөгийг зарим шавьж, шувуу, хулгана, шоргоолж зэрэг хорлогчдоос хамгаалах.

Зөгийн багаж хэрэгслүүд

Дулаан тохилог өвөлжөө, байр, модон гэрүүд/хайрцагууд, утуур, ховхчуур, эх хадгалах тор, идүүр, сүрэлтэл барих сав, сэмж наах өнхрүүш, сэмж, жаасны төмөр утас, шөвөг, бахь, алх гэрийн бэхэлгээ, лавны хутга, лав хайлуулах төхөөрөмж, бал юулүүр, торон малгай, хувцас, зэрэг тоног хэрэгслүүд шаардлагатай.



Манай хааг: Даян Дэлхийн Байсалт Орчны Сангийн

Жижиг Тослийн Хотлолбор, НУБ-ын Хөгжлийн Хотлолбор,

НУБ-ын байр, НУБ-ын Худалгас-14, Сүхбаатар дүүрэг,

Улаанбаатар-14201, Монгол улс.

Утас: 976 (11) 327585 ext-1140, 70112883

Цахим шуудан: gambaatar.bandi@undp.org

narangaarav.gankhuyag@undp.org